

“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН БАЙНГЫН БУС ГИШҮҮНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”, “Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд арилжаанд оролцох байнгын бус гишүүнд энэ шалгуур үзүүлэлтэд үндэслэн биржийн гишүүнчлэл олгоно.
- 1.2. Биржийн байнгын бус гишүүн энэ шалгуур үзүүлэлтийг түүний гишүүнчлэлийн хугацаанд тогтмол хангаж, арилжаанд оролцоно.
- 1.3. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК (цаашид “бирж” гэх)-ийн журамд заасны дагуу тус шалгуур үзүүлэлт, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг биржийн гүйцэтгэх удирдлага батална.
- 1.4. Гүйцэтгэх удирдлага өөрөөр шийдвэрлээгүй бол энэ шалгуур үзүүлэлт, түүнд оруулах нэмэлт өөрчлөлтийг хүчин төгөлдөр мөрдөж эхлэх өдрөөс хуанлийн 14 хоногийн өмнө нийтэд мэдэгдэнэ.

Хоёр. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

- 2.1. Биржийн байнгын бус гишүүнээр элсэх хуулийн этгээд нь дараах үндсэн шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:
 - 2.1.1. Монгол улсын хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаагаа явуулж буй хоршоо эсвэл дундын хоршоо байх;
 - 2.1.2. Үйл ажиллагаа явуулж буй тухайн сумын малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлэх боломжтой байх.
- 2.2. Биржийн байнгын бус гишүүн нь дараах шалгуур үзүүлэлтийг тогтмол хангаж ажиллана. Үүнд:
 - 2.2.1. Өөрийн гишүүдэд биржийн зах зээлийн мэдээлэл өгөх, тухайн хоршоог төлөөлж бирж болон биржийн байнгын гишүүнтэй харилцах, биржийн арилжаанд оролцох, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажилтантай байх;
 - 2.2.2. Барааны чанар стандартыг хариуцах, өөрийн гишүүдийн захиалгад харгалзах бараа, түүхий эдийг биржийн барааны тодорхойлолтод заасны дагуу хүлээн авах, хүлээлгэн өгөх ажилтантай байх;
 - 2.2.3. Тусгайлан тохижуулсан ажлын байртай байх¹;
 - 2.2.4. Хавсралт 1-д заасан техникийн шаардлагыг хангасан компьютер, тоног төхөөрөмжтэй байх;
 - 2.2.5. Хавсралт 2-т заасан холболтын схем бүхий интернэт холболттой байх;
 - 2.2.6. Биржээр арилжих бараа, түүхий эдийг хадгалах, анхан шатны тордолт хийх боломжтой өөрийн эсвэл гэрээт итгэмжлэгдсэн агуулахтай байх.

Гурав. БАЙНГЫН БУС ГИШҮҮНЭЭР ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

- 3.1. Энэ шалгуур үзүүлэлтийн 2.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан байнгын бус гишүүнээр элсэхийг хүсч буй хуулийн этгээд нь биржийн маягтын дагуу өргөдөл гаргаж, биржид ирүүлнэ.
- 3.2. Байнгын бус гишүүнээр элсэхийг хүсч буй хуулийн этгээдийн өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх хүртэлх хугацаанд дараах бичиг баримтуудыг бүрдүүлсэн байна. Үүнд:

¹ Тусгайлан тохижуулсан ажлын байр гэдэгт биржийн арилжаанд оролцох, өөрийн гишүүдэд мэдээлэл өгөхтэй холбогдуулан тусгаарлан тохижуулсан, ажилтнууд ажиллах хэвийн нөхцөлөөр хангагдсан танхимыг ойлгоно.

- 3.2.1. Байнгын бус гишүүнээр элсэх өргөдөл²;
 - 3.2.2. Эрх бүхий албан тушаалтан³, энэ шалгуурын 2.2.1 болон 2.2.2-т заасан ажилтнуудын анкет⁴;
 - 3.2.3. Хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;
 - 3.2.4. Хоршооны дүрмийн хуулбар;
 - 3.2.5. Хоршооны үйл ажиллагааны төлөвлөгөө⁵;
 - 3.2.6. Энэ шалгуурын 2.2.1 болон 2.2.2-т заасан ажилтнууд тухайн хоршооны ажилтан болохыг нотлох хоршооны даргын тодорхойлолт;
 - 3.2.7. Энэ шалгуурын 2.2.3 болон 2.2.6-д заасныг нотлох гэрэл зураг;
 - 3.2.8. Компьютер, техник тоног төхөөрөмж болон интернет холболт техникийн шаардлагад нийцэж буйг нотлох баримт;
 - 3.2.9. Аливаа санхүүгийн бичиг баримт⁶-д тухайн хоршоог төлөөлөх этгээдийн гарын үсгийн баталгаа⁷;
 - 3.2.10. Үйл ажиллагаа явуулж буй сумын малчин өрхөд үйлчилгээ үзүүлэхээр байгуулсан гэрээ⁸-ний хуулбар, жагсаалтын хамт.
- 3.3. Энэ шалгуур үзүүлэлтийн 3.2.3 болон 3.2.4-т заасан хуулбаруудыг нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай бөгөөд боломжгүй тохиолдолд тухайн бичиг баримтын эх хувийг, хуулбарын хамт авчирч болно.
- 3.4. Байнгын бус гишүүнээр элсэхийг хүсч буй хуулийн этгээд нь түүний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх хүртэлх хугацаанд биржээс тодруулсан эсвэл нэмж шаардсан мэдээлэл, бичиг баримтыг тухай бүрт гаргаж өгнө.

Дөрөв. БАЙНГЫН БУС ГИШҮҮНИЙ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

- 4.1. Энэ шалгуур үзүүлэлтийн 3.2-т заасан бичиг баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв бүрдүүлж биржид ирүүлснээс хойш 30 хоногийн хугацаанд тухайн өргөдөл гаргаж буй хуулийн этгээдийг биржийн байнгын бус гишүүнээр элсүүлэх эсэх дүгнэлтийг гаргаж, гэрээ байгуулах эрх олгосон эсвэл олгоогүй тухай мэдэгдэнэ.
- 4.2. Байнгын бус гишүүний гэрээг биржийн гүйцэтгэх удирдлагын баталсан байнгын бус гишүүний гэрээний загварын дагуу байгуулна.
- 4.3. Байнгын бус гишүүний гэрээ байгуулсны дараагаар тухайн байнгын бус гишүүний албан хүсэлтийг үндэслэн дараах програмыг байнгын бус гишүүний ажлын байранд суулгаж болно. Үүнд:
 - 4.3.1. Арилжааны програм;
 - 4.3.2. Агуулахын бүртгэлийн програм;
 - 4.3.3. Биржийн гүйцэтгэх удирдлагын баталсан бусад.

² Биржээс боловсруулан гаргасан өргөдлийн биржийн маягтыг хэлнэ.

³ Эрх бүхий албан тушаалтан гэдэгт тухайн хуулийн этгээдийн удирдах албан тушаалтныг ойлгоно.

⁴ Биржээс боловсруулан гаргасан анкет байна.

⁵ Төлөвлөгөөг биржийн маягтын дагуу гаргасан байна.

⁶ Санхүүгийн бичиг баримт гэдэгт дэнчингийн хүсэлт, худалдах худалдан авах гэрээ, биржийн нэхэмжлэх зэргийг ойлгоно.

⁷ Биржийн маягтаар хоршооны албан бланкан дээр гаргасан байна.

⁸ Энэхүү гэрээ нь биржийн маягтаар байгуулсан эсвэл биржээс тавьсан нөхцөл шаардлагыг хангасан гэрээ байна.

ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Арилжааны болон агуулахын програм суулгах компьютер:


№	Нэр	Үзүүлэлт
1	<i>Процессор (CPU)</i>	Intel core i5, 3.0GHz ба түүнээс дээш
2	<i>Нөөцлөх санах ой (Cache)</i>	2MB ба түүнээс дээш
3	<i>Түр санах ой (RAM)</i>	4GB ба түүнээс дээш
4	<i>Хатуу диск (HARD DISK)</i>	500GB ба түүнээс дээш
5	<i>Үйлдлийн систем (OS)</i>	Windows 7 буюу түүнээс дээш
6	<i>Нэмэлт график карт</i>	2 буюу түүнээс дээш дэлгэц холбоход ашиглах

2. Арилжаанд оролцох, гишүүдэд мэдээлэл өгөхөд ашиглах дэлгэц:

- ✓ 40"-ээс дээш байвал тохиромжтой

АЖЛЫН БАЙРАНД БАЙРЛУУЛАХ КОМПЬЮТЕР, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХОЛБОЛТЫН СХЕМ БОЛОН ИНТЕРНЭТИЙН ШААРДЛАГА

1. Холболтын схем:



Зурагтыг (3)- тай холбоход HDMI залгуур ашиглана.

— дотоод сүлжээний кабель

- - - телефоны шугам

2. Интернетийн шаардлага:

- ✓ 1 терминалын хувьд 512KB-ээс дээш хурдтай байх